

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Цахим хөгжлийн багц хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2022 оны 11 дүгээр сарын 01-ээс 11 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллав.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрөл, цахим үйлчилгээний чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд 960 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 688 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 272 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад илгээлээ. (Хүснэгт 1)

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 297 гадаадын иргэнд хилийн боомтод, төвд 4 гадаадын иргэнд буюу нийт 301 гадаадын иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз олгосон. Мөн 4 иргэнд гарах-орох цагаачийн мэдэгдэл олголоо. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Визийн зөвшөөрөл		Виз	Оршин суух зөвшөөрөл			Түр ирэгч	
Хилийн чанадад	Хилийн боомтод		олгосон	сунгасан	хэлбэр, төрөл өөрчилсөн	хаягийн бүртгэл	байх хугацаа сунгалт
688	272	301	1226	1019	0	489	311
960							


1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 1226 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 1019 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 1107 иргэний бүртгэлд хасалт хийсэн. (Хүснэгт 1)

Гадаадын иргэнийг уригч 36 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 191 гадаадын иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 489 гадаадын иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэсэн. Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй

зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 311 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. (Хүснэгт 1)

График 1



Дээрх тоон үзүүлэлтийг 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 59.2 хувь, виз олголт 30.5 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 54.6 хувиар тус тус өсөж, оршин суух зөвшөөрлийн сунгалт 11.7 хувиар буурчээ.

“Монгол Улсад оршин суух үнэмлэх” 1413 ширхэг шинээр хэвлэж, 612 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 41 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн 108 гадаадын иргэний хүсэлтийг байгууллагын даргын 3 удаагийн тушаалаар шийдвэрлэж, 5 иргэнд регистрийн дугаар олгосон.

1.1.3. Цахим үйлчилгээ, программ хангамж:

Энэ сард нийт 981 аж ахуйн нэгж, байгууллагын 3430 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ.

Визийн мэдээллийн нэгдсэн сан “evisa.mn” системээр нийт 26 улсын 418 иргэнд цахим виз олгож, 5 улсын 31 гадаадын иргэний визийн хүсэлтэд татгалзсан.

Eimmigration.mn системд төлбөр тооцооны QPAY нэвтрүүлэхээр хөгжүүлэлтийг эхлүүлээ.

Оршин суух үнэмлэх хэвлэх программ (RCP) хангамжийг хөгжүүлэн 11 дүгээр сарын 17-ны өдөр ажиллагаанд оруулж, тест хэвлэж бэлтгэв.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн байгууллагын цахим хуудас (immigration.gov.mn)-д холбогдох өөрчлөлт оруулсан.

1.1.4. Зөвлөгөө, мэдээлэл:

Тайлант хугацаанд гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт,

визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 3686 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

1800-1882 утас	Биечлэн	Имэйл	Нийт
4141	254	27	4422

Визийн зөвшөөрлийн код бүхий имэйлийг 651 иргэнд илгээлээ.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Иргэний харьяалал:

Харьяатын асуудлаар нийт 16 иргэн, 3 харьяалалгүй хүний хүсэлтийг шинээр хүлээн авч, 18 иргэн, 3 харьяалалгүй хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг явууллаа. (Хүснэгт 4)

Хүснэгт 3

Хугацаа	Монгол Улсын харьяат болсон	Иргэний харьяаллыг сэргээн тогтоосон	Монгол Улсын харьяатаас гарсан	Хоёрдмол харьяалалтай иргэнийг бүртгэсэн
11 дүгээр сар	-	-	-	133
2022 он (өссөн дүнгээр)	2	1	-	547

Түүнчлэн 19 иргэн, 5 харьяалалгүй хүний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 16 иргэний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн. (Хүснэгт 4)

Хүснэгт 4

Иргэний харьяаллын талаарх сарын мэдээ						
д/	Харьяалах улс	Хүлээн авсан хүсэлт	Түдгэлзүүлж буцаасан хүсэлт	Саналд илгээсэн	ЗГХЭГ-т хүргүүлсэн	ЕТГ-т хүргүүлсэн
Монгол Улсын харьяат болох						
1	Оросын Холбооны Улс	-	-	-	1	-
	нийт	-	-	-	1	-
Монгол Улсын харьяатаас гарах						
1	Монгол Улс	16	-	18	18	16
	нийт	16	-	18	18	16
Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох						
1	Харьяалалгүй хүн	3	-	3	5	-
	нийт	3	-	3	5	-

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болохоор дараах 16 иргэн хүсэлт, баримт бичиг шинээр ирүүлснийг хүлээн авсан байна.

- Бүгд Найрамдах Казахстан Улсын харьяат болох 8;
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын харьяат болох 5;
- Япон Улсын харьяат болох 3 иргэн.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгохоор харьяалалгүй 3 хүний ирүүлсэн хүсэлтийг мөн хүлээн авлаа.

“Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 52 улсын 4418 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна.

Тайлант хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 133 иргэнийг “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д шинээр бүртгэсэн. (Хүснэгт 3)

Тагнуулын ерөнхий газартай хамтарсан удирдамжийн дагуу Улаанбаатар хот болон Ховд, Баян-Өлгий, Дархан-Уул аймагт оршин сууж буй хоёрдмол харьяалалтай иргэдийн баримт бичигт 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл хяналт шалгалт явууллаа.

“Дэлхийн улс орнуудын давхар харьяаллын талаарх баримталж буй бодлого” сэдвээр харьцуулсан судалгаа хийж, танилцуулгыг 11 дүгээр сарын 29-ний өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт цахим хэлбэрээр хүргүүлээ.

1.2.2. Хүүхэд үрчлэлт:

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Итали Улсын 1 иргэн, гэр бүлийн хүсэлт, баримт бичгийг 11 дүгээр сарын 23-ны өдөр шинээр хүлээн авсан.

Гадаадын иргэн, гэр бүлд үрчлүүлсэн Монгол Улсын харьяат 93 хүүхдийн мэдээллийг шинэчлэх зорилгоор 11 дүгээр сарын 16, 29-ний өдрүүдэд зуучлалын 3 байгууллагын мэдээллийг “Гадаад улсын иргэнд үрчлүүлсэн Монгол Улсын хүүхдийн мэдээллийн сан” дахь бүртгэлтэй тулгах ажиллагаа явуулав.

11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд нийт 274 Монгол хүүхдийг үрчлүүлээд байна.

1.2.3. Олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Тайлант хугацаанд Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн 3 газрын баримт, бичгийг хүлээн авлаа.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн 78 газар бүртгэлтэй байна.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Төлөвлөгөөт 2 удаагийн хяналт шалгалтаар 90 аж ахуйн нэгж байгууллага, 91 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгаж, 2 аж ахуйн нэгж, байгууллагад албан шаардлага хүргүүлэв.

Төлөвлөгөөт бус 34 удаагийн хяналт шалгалтад 39 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан, 241 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгаж, 26 зөрчлийг илрүүлээ.

Хүснэгт 5


Хувь хүн		Уригч байгууллага			Уригч хувь хүн		
Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/
15	1,500,000	-	-	-	-	-	-
нийт 1,500,000 төгрөг							
Үүнээс гадаадын иргэн							
Хуулийн үндэслэл		Шалтгаан					Гадаадын иргэний тоо
Зөрчлийн тухай хууль 16.2-1.2		нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн					14
Зөрчлийн тухай хууль 16.2-1.5		ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан					1
бүгд						15	

Тайлант хугацаанд 6 улсын 15 гадаадын иргэнд холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн дагуу нийт 1,500,000 төгрөг (Нэг сая таван зуун мянган)-ийн торгох шийтгэл оногдууллаа. (Хүснэгт 5, 6)

Хүснэгт 6

Торгуулсан гадаадын иргэн (тухайн сараар)					
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл		Бүгд	Торгуулийн дүн
		16.2-1.2	16.2-1.5		
1	Америк	1	-	1	100,000
2	Вьетнам	1	-	1	100,000
3	Герман	1	-	1	100,000
4	Өмнөд Солонгос	1	-	1	100,000
5	Франц	1	-	1	100,000
6	Хятад	9	1	10	1,000,000
Нийт		14	1	15	1,500,000

График 2



Холбогдох хугацааны тоон үзүүлэлтийг 2021 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 2.7 дахин, зөрчил гаргасан уригч иргэн 2 дахин, албадан гаргасан гадаадын иргэн 96.8 хувь, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 77.8 хувь, саатуулсан гадаадын иргэн 50.0 хувиар тус тус өсөж, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 25.0 хувиар буурсан байна.

1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.2 дахь заалтыг үндэслэн 3 улсын 6 иргэний Монгол Улсын хилээр гарах эрхийг байгууллагын даргын 6 удаагийн тушаалаар түр түдгэлзүүлж, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь заалтыг үндэслэн тус улсаас гарахыг түдгэлзүүлсэн 1 улсын 1 иргэний хилээр нэвтрэх эрхийг 1 удаагийн тушаалаар сэргээсэн байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, 37.1.11, 37.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн 3 улсын 13 иргэнийг байгууллагын даргын 5 удаагийн тушаалаар албадан гаргахаар шийдвэрлэлээ. (Хүснэгт 9)

Хүснэгт 9

Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний мэдээ (тухайн сараар)					
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл			Нийт
		37.1.7а	37.1.11	37.1.12	
1	Йордан		1		1
2	Саудын Араб		5		5
3	Хятад	5	1	1	7
	Бүгд	5	7	1	13

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7.4, Засгийн газрын 2021 оны 193 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 5.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн 1 улсын 1 иргэнийг 1 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан шийдвэрийг хугацаанаас өмнө цуцалсан.

Тайлант хугацаанд виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн үндэслэлээр нийт 8 улсын 299 иргэнийг Монгол Улсын хилээр оруулахгүй буцаасан. Үүнээс:

- Хойд бүс дэх газар виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн 8 улсын 296 гадаадын иргэнийг,
- Зүүн бүс дэх газар 1 улсын 2 иргэнийг,
- Баян-Өлгий аймаг дахь хэлтэс Монгол Улсын харьяатаас гарсан боловч Монгол Улсын иргэний баримт бичгээр улсын хилээр орохыг завдсан харьяалалгүй 1 хүнийг тус тус Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаажээ.

Түүнчлэн Хойд бүс дэх газар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн 1 улсын 1 иргэнийг хилээр гаргаагүй байна.

